

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй

Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 31-ны өдөр	2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: “Хай Би Ойл” ХК УБД: 9010001063, РД:2615134 Үнэт цаасны код: Утасны дугаар: 88119740, 88035811
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын Хөрөнгийн Бирж” ХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Үйлдвэрлэлийн салбар: Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	52,118,954
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Хагас жилийн тайлан бэлтгэсэн: Менежер: Л.Даваагэрэл, ТУЗ НБД Н.Батнайрамдал Хагас жилийн тайланг хянасан: ТУЗ дарга: Б.Батбаатар
1. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/-Тайланг хавсаргав.	
Санхүүгийн байдлын үзүүлэлт 2026 оны 2-р улиралд нийт хөрөнгийн дүн 5,671.8 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 15,2% буюу 862.6 сая төгрөг, эргэлийн бус хөрөнгө 84,8% буюу 4,809.0 сая төгрөг байна. Нийт хөрөнгийн эх үүсвэр 5,671.7 сая төгрөг, үүнээс өр төлбөр нь 79.6 сая төгрөг, эзний өмч 5,592,0 сая төгрөг байна Орлогын тайлан 2026 оны хагас жилийн нийт орлого 179,3.4 сая төгрөгийн орлоготой 129,5 сая төгрөгийн зардал, 1.7 сая төгрөгийн бусад зардал, 12,9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Өмчийн өөрчлөлтийн тайлан 2026 оны хагас жилээр алдагдалтай ажиллаж 1-р улиралын эцэст эзний өмчийн дүн 5,592.0 сая төгрөг байна Мөнгөн гүйлгээний тайлан 2026 оны хагас жилийн мөнгөн орлого 197.2 сая төгрөг, зарлага нь 350.3 сая төгрөг, үйл ажиллагааны гүйлгээ 153.1 сая төгрөг, улиралын эцсийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 356,1 сая төгрөг	
2. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт-байхгүй	
3. Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйл, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага,	

ашгийн үзүүлэлтүүдийг тооцож, дүгнэсэн удирдлагын тайлан дүгнэлт-байхгүй	
3.1.Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлт/	
3.2.Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлт	
3.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад,дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт,дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.
3.4.Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
4. Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
<i>Тайлан хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байхгүй</i>	
5. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
<i>Тайлант хугацаанд татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.</i>	
6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл:	
1) 2026 оны 04 сарын 27-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 18135 товчооны зам гудамж, 59 тоотод зарлан хуралдуулж дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.	
а) Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;	
б) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;	
Дээрх хуралдааны тогтоол шийдвэрүүдийг Монголын Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн бирж, түүний вэб хуудаснуудад тухай бүр өгч хууль дүрэм, журмын дагуу байршуулан ажилласан.	
Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:	
Компани нь нийт 52,118,954 ширхэг хувьцаатай ба 39 хувьцаа эзэмшигчидтэй байна.	
Үүнээс нийт хувьцааны 5% буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:	
№	Хувьцаа эзэмшигчийн нэр Нийт хувьцааны
	Тоо ширхэг Хувь
1	“Төгөлдөр мегаминкс” ХХК 8 256 727 16.15%
2	“Кибер циркл” ХХК 16 609 841 32.48%
3	“Монгол алтан минт” ХХК 4 167 934 8.15%
4	“Нью альфа” ХХК 17’327’908 33.89%
	Дүн 90.67%
/ ҮЦТХТ-өөс 20265.04.08-ний өдрөөр тасалбар болгон авсан мэдээ. /	
Удирдлагын талаарх мэдээлэл:	
2026.04.27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр У.Энхбилэг, Б.Батбаатар, Ш.Амар-Отгон, С.Одгэрэл, Р.Оюунбат, Б.Дөлгөөнтамир нар, хараат бус гишүүдээр Б.Гэрэлтуяа, Т.Тамир, Г.Бадамдорж нар сонгогдож, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Батбаатар, Гүйцэтгэх захирлаар Ш.Амар-отгон, ТУЗ-ийн нарийн бичгээр Н.Батнайрамдал нар сонгогдож ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтад хамрагдсан.	
2026 оны ТУЗ-ийн хурлын талаар:	
Тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ нь 4 удаа санал асуулгаар хуралдсан байна.	

Үүнд:

1. 2026 оны 01 сарын 12-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж

А. “Пантер мидлант аудит” ХХК-аар 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай асуудлыг хэлэлцээд “Пантер мидлант аудит” ХХК-аар аудит хийлгэхээр шийдвэрлэсэн.

2. 2026 оны 02 сарын 11-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж 2025 оны жилийн ажлын үр дүнгээс Ногдол ашиг хуваарилах тухай асуудлыг хэлэлцээд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

3. 2026 оны 03 сарын 18-ны өдөр саналын хуудсаар “Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай асуудлыг хэлэлцэж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 сарын 27-ны өдөр хуралдуулахаар шийдвэрлэсэн.

4. 2026 оны 05 сарын 18-ний өдөр саналын хуудсаар хуралдаж, 2026 оны 04 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар томилогдсон ТУЗ-ийн гишүүдээс ТУЗ-ийн дарга, ТУЗ дэргэдэх хороодын бүрэлдэхүүнүүдийг болон ТУЗ-нарийн бичгийн даргыг тус тус томилж шийдвэрлэсэн болно. Мөн ТУЗ-ийн дарга гишүүдийг УБЕГ-ийн Хуулийн этгээдийн бүртгэлийн газар бүртгүүлэх шийдвэрийг гаргасан.

7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Хянасан: Овог, нэр: Б.Батбаатар

Албан тушаал: “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:



Овог, нэр: Н.Батнайрамдал

Албан тушаал: “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичиг

Гарын үсэг:

“Хай Би Ойл” ХК-ийн 2026 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

Төслийн нэр	“Техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр”-ийн төсөл
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	“Хай Би Ойл” ХК
Улсын бүртгэлийн дугаар	9010001063
Регистрийн дугаар	2615134
“Аюултай хог хаягдал” цуглуулах,тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн дугаар	000080
Төслийн байршил	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Сонсголон /18135/, 110 тоот
Талбайн хэмжээ	8858м ²
Утас	88119740, 99904034,
Төслийн зорилго, ач холбогдол	Үйлдвэрлэл, техникийн зориулалтаар ашиглагдаж хэрэглээний шинж чанараа алдсан нефтийн гаралтай тос, тослох материал болох техникийн хаягдал тос болон гидрийн шингэнийг орчин үеийн технологийн VSEP мембранан шүүлтүүрийн аргаар цэвэршүүлж, шаардлага хангасан М-100 маркийн мазут бэлтгэх зорилготой мөн техникийн хаягдал ажилласан маслыг цэвэршүүлэн, байгаль орчин болоод хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах, аюултай хог хаягдлын хэмжээг бууруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилготой.
Ажиллах хоног	240 хоног
Цахилгаан, ус хангамж	Цахилгаан нь МЗХННУлаанбаатар Төмөр Замын шугам сүлжээнд холбогдсон. Үйлдвэрийн хэрэглээний болон ажилчдын ундны усыг өөрийн эзэмшлийн худгаас хангадаг.

Мазутын шинжилгээ

Тус үйлдвэрийн технологиор автомашины хөдөлгүүрийн хаягдал тос болон гидрийн шингэнийг цэвэршүүлэн М-100 маркийн мазут үйлдвэрлэдэг байна. Дахин боловсруулсан тос буюу мазутыг уурын зуух болон цахилгаан станц, асфальт бетон зуурмагийн үйлдвэр, халаагуур эсвэл хайлуулах зуух, цементийн зуух гэх мэт үйлдвэрлэлд галалгааны түлш хэлбэрээр хэрэглэдэг.


Мазутад тавигдах техникийн нөхцөлийг “Газрын тосны бүтээгдэхүүн, Мазут Техникийн ерөнхий шаардлага MNS 3828:2008” стандартад нийцүүлдэг. Уг стандартад барьцалдах чанараараа

хөнгөн түлш болох флотын мазут Ф-5, Ф-12 мөн дунд ангиллын М-40 болон хүнд ангиллын М-100 маркийн зуухны мазут гэж тус бүр ангилсан байдаг.



АМБЕР ХХК

Газрын тос, Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний
MNS ISO/IEC 17025 стандартаар итгэмжлэгдсэн лаборатори



СОРИЛТЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН №04755/26

ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ		
Дээж ирүүлэгч байгууллагын нэр	Хай Би Ойл ХК	
Дээжийг авсан газар	Улаанбаатар, Монгол	
Дээжийн төрөл	Мазут	
Дээж авсан объект	Сав	
Дээж авсан ажиглан өгөгчдийн нэр	Хай Би Ойл ХК-ийн ажиглан	
Дээжийн хэмжээ	1.5 литр	
Дээжийн лацны дугаар	-	
Дээжийн нэмэлт тайлбар	-	
Дээж авсан огноо: 2026.06.09	Хүлээн авсан огноо: 2026.06.10	Шинжилсэн огноо: 2026.06.11

СОРИЛТЫН ҮР ДҮН

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Сорилт гүйцэтгэсэн стандарт	Норм MNS 3828:2008 /M-100/	Үр дүн
1 15°C дахь хувийн жин	г/см ³	MNS 0481	-	0.8769
2 Кинематик зууралдлага 50 °C-т	мм ² /с	MNS 0480	-	60.55
Кинематик зууралдлага 100 °C-т, ихгүй			50.0	8.94
3 Задгай тивчлэл дотуур үүсгэх температур, багагүй	°C	MNS 0328	110.0	>120
4 Механик хольцон агуулга, ихгүй	%	MNS 0322	1.0	байхгүй
4 Усны агуулга, ихгүй	%	MNS 0332	1.0	байхгүй
5 Царцах температур, дээшгүй	°C	MNS 3192	25.0	<21.0
6 Онго*	-	MNS ISO 2049	-	Хар

Тайлбар: * - ИХ-о ороогүй үзүүлэлт

Шинжилгээ хийсэн химич

Баталгаажуулсан лабораторийн эрхлэгч



Г.Уранхайч

М.Мидэгмаа

НАРНЫ ЗАМ 11, СБД 2, УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС 14251


Энэхүү тайлан нь тухайн дээжний хувьд хучинттай.
Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

000162003

Зураг 1. Мазутын шинжилгээ

1.Сөрөг нөлөөллийг бууруулах биелэлт

Үйлдвэр доторх агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах газрын гадаргаас тоос тоосонцор агаарт дэгдэх магадлал өндөр,тоосжилтыг дарах, үйлдвэрийн зохион байгуулалтыг сайжруулахын тулд тоног төхөөрөмжний шугам хоолой, нацосыг засаж сайжруулсан.



Зураг:2. Үйлдвэрийн тоног төхөөрөмжний засвар үйлчилгээ

2.Осол эрсдлийн биелэлт

Аюулгүй байдлын хангах чиглэлээр нийслэл хот дотроо үйл ажиллагаа явуулдаг авто засварын газруудаас Техникийн ашигласан хаягдал тос тээвэрлэдэг зориулалтын автомашинд хот дотор явах ЕС зөвшөөрлийн сунгалтыг хийлгэж хагас жилээр түр зөвшөөрлөө авсан. Ажилчдын унаа машин (Prado, Starex) болон тосны цистернуудад (Kia Rhino) ээлжит урсгал засвар тээврийн хэрэгслийн татвар, улсын үзлэг, оношилгоо, даатгалд зэрэгт хамруулсан.

Техникийн ашигласан хаягдал тос цуглуулж, тээвэрлэдэг зориулалтын автоцистерн 64-45УКМ, 65-44 УКН автомашинуудад Нийслэлийн Онцгой байдлын газраас галын авулгүй байдлын дүгнэлт гаргуулсан.




Зураг 3. Тээврийн хэрэгслийн ЕС зөвшөөрөл



Зураг 4. Тээврийн хэрэгслийн галын аюулгүй байдлын дүгнэлт

3. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулан ажиллаж байна. Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах (хоолны үлдэгдэл, цаас хайрцаг сав баглаа боодол) хүмүүсийн хэрэглэж байсан зүйлс багтана. Нийт 8 хүн ажиллах бөгөөд жилд 140 хоног ажиллана гэж тооцвол өдөрт 4 кг, сард 120кг (8 хүн хоног 0,5кг хатуу хогхаягдал/хоногт*30 хоног), жилд 840кг хог хаягдал гарахаар байна. Харин үйлдвэрээс гарах саарал усыг Здамжлагат тунгаах саванд хийсний дараа хөргөлтийн системд дахин ашиглаж байна.



Зураг 5. Ахуйн хог хаягдал



ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ХУРААХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1 Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, төсөвт болон төрийн бус байгууллагуудын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж ачих, тээвэрлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

2.1 Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн шинэчилсэн найруулга Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.3, 41.5, 41.8, 43 дугаар зүйл, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн баталсан "Хог тээвэрлэгчийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журам", Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/01-р тогтоолыг үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

2.2 Энэхүү гэрээг 2615134

НЭГ ТАЛААС: Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс /цаашид татварын байцаагч гэх / Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх "Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний төв" ОНӨААТҮГ /цаашид тээвэрлэгч гэх/с

НӨГӨӨ ТАЛААС: *Аж ахуй* иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага /доогуур зурах/ *Дэвшил байгуулах үндсэр* үйл ажиллагааны чиглэлтэй /цаашид үйлчлүүлэгч гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1 2026 оны 01 -р сарын 01-ны өдрөөс эхлэн

2026 оны 12 -р сарын 31 өдрийг дуустал хүчин төгөлдөр үйлчилнэ.

ДӨРӨВ. ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Татварын хууль тогтоомжид заасны дагуу татварын байцаагч нь сар бүрийн 25-ны дотор гэрээнд заасан үнийн дүнгээр хог хаягдлын хураамжийг хураан авах эрхтэй.

4.2 Гэрээнд зааснаар үйлчлүүлэгч нь гэрээний үүргийг биелүүлээгүй болон биелүүлэхээс татгалзсан тохиолдолд татварын алба нь Татварын ерөнхий хуулийн

55 дугаар зүйлээс 73 дугаар зүйлд заасан процесс ажиллагааг хийх эрхтэй.

4.3 Аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр тээвэрлэгч байгууллагатай тооцоо нийлж байх үүрэгтэй.

4.4 Татварын байцаагч нь аж ахуй нэгж байгууллага бүрээс хог хаягдлын хураамжийг тогтсон хугацаанд, тогтмол хурааж тээвэрлэгч байгууллагын ажилт хийх боломжийг хангах үүрэгтэй.

4.5 Аж ахуй нэгжээс нэхэмжлэлээр хураасан хог хаягдлын хураамжийн задаргааг тээвэрлэгч байгууллагад дараа сарын 3-ны дотор аж ахуй нэгж, байгууллага гаргаж өгөх.

ТАВ. ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Тээвэрлэлт хийсэн аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр Татварын хэлтэстэй тооцоо нийлж байх үүрэгтэй.

5.2 Гэрээний үнийн дүн болон ачуулж байгаа хог, тээвэрлэлтийн зардал бодит байдал дээрээ хоорондоо нийцэхгүй тохиолдолд тээвэрлэгч байгууллагаас татварын хэлтэст ИТХ-ийн 10/01 дугаар тогтоолд заасан тарифын дагуу үнийн санал гаргаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.

5.3 Үйлчлүүлэгчийн хог хаягдлыг тээвэрлээгүйтэй холбоотой гомдол гаргавал тооцоо нийлж, протокол үйлдэж, тээвэрлэлтийн баримтаар нотлогдоогүй бол хохирлыг тээвэрлэгч байгууллага барагдуулах үүрэгтэй.

5.4 Хог хаягдлын ачилт хийсэн хуудас, нэхэмжлэлийг сар бүрийн 20-ны дотор Татварын хэлтэс өгч, ачилт хийсэн аж ахуй нэгж, иргэн, албан байгууллагын мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

5.5 Тээвэрлэгч байгууллага нь Татварын хэлтэстэй тооцоо нийлсний үндсэн дээр хог хаягдлын хураамжаа 3 сараас дээш төлөөгүй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хогийг тээвэрлэхгүй.

ЗУРГАА. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 Өөрийн гаргасан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тогтсон хогийн цэгт хаях болон өвөр хэмжээнээс хамаарч хогны захиалгыг урьд өдөр нь тээвэрлэгч байгууллагын 70000818 дугаарын утсанд ажлын цагаар дуудлага өгнө. Гэрээнд заасан тарифийн дагуу тогтмол рейсийн тоогоор тээвэрлүүлэх.

6.2 Татварын байцаагчаас хог хаягдлын хураамж тушаасан баримт, Тээвэрлэгч байгууллагаас хог хаягдлыг ачуулсан баримтыг шаардан авах эрхтэй.

6.3 Захиалгаар болон тогтсон хуваарийн дагуу очсон тээвэрлэгч авто машиныг хоосон буцаасан, халуун үнс нурамтай, цогтой, хөлдүү хог хаягдал зэргээс шалтгаалж хог ачих, тээвэрлэх, нөхцөл боломжийг бүрдүүлээгүй, тохиолдолд гарсан зардлыг тухайн аж ахуй нэгж байгууллага болон иргэн өөрөө хариуцна.

6.4 Үйлчлүүлэгч нь тогтсон хугацаанд татварын байцаагчид гэрээний дагуу хог хаягдлын хураамжийг төлж байх. Тээвэрлэгч байгууллагад тогтсон хугацаанд зориулалтын цэгээс, уут саванд хийсэн хог хаягдлыг саадгүй ачуулах үүрэгтэй.

6.5 Ажиллаагүй гэсэн шалтгаанаар хог хаягдлын хураамж төлөөгүй аж ахуй нэгж, иргэн, албан байгууллага тухайн харьяалагдах хорооноос ажиллаагүй гэсэн албан бичиг авч баримтжуулах үүрэгтэй.

6.6 Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2-т заасны дагуу шаардлага хангасан зориулалтын хогийн савтай байх үүрэгтэй.

ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО

7.1 Эрх зүйн баримт бичиг болон стандартад өөрчлөлт орсон тухайн цаг үед гэрээ байгуулсан талуудаас санал оруулах нь нээлттэй.

7.2 Үйлчлүүлэгч /рейсийн/ үйлчилгээний хураамжийг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/01 дугаар тогтоолоор тогтоосон тарифын дагуу /сар бүрийн.....төгрөг/, /улиралд.....төгрөг/, /жилд.....төгрөг/, /захиалгаар.....180,000.....төгрөг/ төлбөрийг төлнө.

7.3 Татвар төлөгч нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлбөрийн даалгаврыг үүсгэн банкинд төлнө.

7.4 Татварын хэлтэс нь хураасан мөнгөн дүн болон төлбөр өгсөн аж ахуй нэгж, байгууллагын нэрсийг сар бүрийн 05-ны дотор гаргаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах үүрэгтэй.

7.5 Хүний гараар ачих боломжгүй, тусгай техник хэрэгсэл ашиглах шаардлагатай хогийг тээвэрлэгч байгууллагаас тусгай машин, техник гаргаж ачуулсан тохиолдолд гарах зардлыг хариуцсан этгээдээр нэмж гаргуулна.

НАЙМ. ГЭРЭЭ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

8.1 Энэхүү гэрээтэй холбоотой гарсан маргааныг харилцан тохиролцох бөгөөд шийдвэрлэж чадахгүй нөхцөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

8.2 Гэрээний биелэлт дээр татварын хэлтэс, тээвэрлэгч, үйлчлүүлэгч байгууллагууд харилцан хяналт тавьж ажиллана.

8.3 Үйлчлүүлэгч автомашинд сул зогсолт үүсгэж, буцаасан тохиолдолд хураамжийн үнийн 50 хувийг тээвэрлэгчид төлөх үүрэгтэй.

8.4 Энэхүү гэрээний 4.4-д заасныг хэрэгжүүлээгүй тохиолдолд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах. Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээг авна.

8.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.5 хувиар алданги тооцно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Сонгинохайрхан Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний төв ОНӨААТҮГ төлөөлж:
Албан тушаал: Хуулийн зөвлөх
Нэр: Ж.Амарсанаа
Гарын үсэг: *Амарсанаа*

Аж ахуй нэгж, байгууллагыг төлөөлж:
Албан тушаал: *Аж ахуйн бодлогч*
Нэр: *О.Талчиг*
Гарын үсэг: *О.Талчиг*
Утас: *99904034*
Хаяг:

УБХТБ СХД - 20-р хороо
Сонгинохон 18135, Төвчөөний
Зам 59 тоот

Зураг 6. Хог хаягдалын гэрээ

4. Орчны хяналт шинжилгээний менежментийн толовлогөөний биелэлт

Байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын хүрээнд төслийн талбайгаас худгийн ус, бохир ус, агаар, хөрсний бохирдлын түвшинг тодорхойлох зорилгоор дээж авч “Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори”ХХК-ийн хөрс судлалын лабораторид шинжлүүлэв.



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohul@scnail.com

СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/№	: 2025/ Ц-65
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Хай Би Ойл” ХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Даваагэрэл, 80010277
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьц авсан огноо	: 2026.06.17
Сорьцын тодорхойлолт	: Худгийн ус
Шинжилгээний аргын стандарт	MNS 6836:2020, MNS 6833:2020 MNS 1097:2023, MNS 6779:2019 MNS 6834:2020, MNS ISO 6878:2001 MNS 4430:2005, MNS 6272: 2011
Шинжилсэн огноо	: 2026.06.17-2026.06.29
Хуудасны тоо	: 1 /2
Үр дүн	: 1

Сорьц авсан цэг	Ж/б мг/л	ПИЧ мг/л	NH ₄ мг/л	NO ₂ мг/л	NO ₃ мг/л	PO ₄ мг/л	Fe мг/л	F мг/л
СХД 20-р хороо Хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр	<0.1	0.9	1.12	0.039	0.62	0.010	0.17	0.44
MNS 0900:2018	-	-	1.5	1.0	50	3.5	0.3	0.7-1.5

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, ПИЧ-Перманганатын Исэлдэгч Чанар

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:

Шалгасан ахлах шинжээч:

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч:



Б.Анужин

С.Отгонжаргал

Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй.



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzi@gmail.com

СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/№	: 2026/ Ц-65
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: "Хай Би Ойл" ХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Даваагэрэл, 80010277
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьц авсан огноо	: 2026.06.17
Сорьцын тодорхойлолт	: Худгийн ус
Шинжилгээний аргын стандарт	ISO 10523:2008, MNS ISO 7888:1999 MNS 1097:2023, MNS 4424:2005 MNS 6832:2020
Шинжилсэн огноо	: 2026.06.17-2026.06.29
Хуудасны тоо	: 2 /2
Үр дүн	: 1

Сорьц авсан цэг	pH	EC мкСм/см	SO ₄ мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO ₃ мг/л	Эрд мг/л	Хат мг-экв/л
СХД 20-р хороо Хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр	7.05	800	111	75.0	108	52.3	10.7	183	540	6.99
MNS 0900:2018	6.5-8.5	1000	500	350	100	30	-	-	-	7.0

Тайлбар: EC - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэсжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:

Шалгасан ахлах шинжээч:

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч:

Б.Анужин
С.Отгонжаргал
Б.Алтантуяа

Б.Анужин

С.Отгонжаргал

Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй.

Зураг 7. Худгийн ус шинжилгээ



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzi@gmail.com

СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/№ : 2026 / Б-80
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Хай Би Ойл" ХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Даваагэрэл, 80010277
Сорьцын тоо, төрөл : 1, бохир ус
Сорьц авсан огноо : 2026.06.17
Сорьцын тодорхойлолт : Бохир усны сорьц
Шинжилгээний аргын стандарт : ISO 10523:2008, MNS 6836:2020
MNS ISO 6060:2001, MNS ISO 5815-1:2015
MNS 1097:2023, MNS 6779:2019
MNS 6834:2020, MNS ISO 6878:2001
Шинжилсэн огноо : 2026.06.17-2026.06.24
Хуудасны тоо : 1 / 1
Үр дүн : 1

Сорьцын авсан цэг	pH	Ж/б мг/л	XXX мг/л	БХХ ₃ мг/л	NH ₄ -N мг/л	NO ₂ -N мг/л	NO ₃ -N мг/л	N _{нийт} мг/л	P _{эд} мг/л
СХД 20-р хороо Хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр Технологийн хаягдал ус	7.09	174	15818	7160	62.9	0.989	8.69	72.58	1.612

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, XXX- Химийн Хэрэгцээт Хүчилтөрөгч, БХХ₃- Биохимийн Хэрэгцээт Хүчилтөрөгч

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч :

Шалгасан ахлах шинжээч:

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч



Б.Анужин

С.Отгонжаргал

Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй.

Зураг 8. Технологын хаягдал усны шинжилгээ

5.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ын дагуу иргэн, аж ахуй нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 20 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх шаардлагыг биелүүлэх ба эзэмшлийн болон өмчлөлийн газрын 20 хувиас доошгүй талбайд улиас, хайлаас, голт бор, үрэл, монос зэрэг мод тарьж, зүлэгжүүлж нөхөн сэргээлт хийх ажлыг хийсэн.



Зураг 9. Мод тарилт